



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар Б/06

Бор-өндөр сум

**Г.Өлзийхишигийг үйлчлэгчийн ажилд
түр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5. Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1. 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1.2, Засгийн газрын 2019 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Нэгдсэн эмнэлгийн даргын 2023 оны “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний ажилчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Б/05 тоот тушаалын хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын хоол унааны хөнгөлөлт, нэмэгдэл, урамшлын хэмжээг тогтоох тухай” А/548 тоот тушаал. 2020 оны “Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай” А/69 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэрэлийн Өлзийхишигийг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн Хэвтэн эмчлүүлэх тасгийн үйлчлэгчээр 3 сарын хугацаатай түр томилон ажиллуулсугай.
2. Г.Өлзийхишигийг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн ТҮ1-1 шатлалаар тогтоон үндсэн цалинг 648.841 (зургаан зуун дөчин найман мянга найман зуун дөчин нэг), хоолны мөнгө өдрийн 3000 (гурван мянга) төгрөгөөр тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-д зөвшөөрсүгэй.
3. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон эмнэлгийн мэргэжилтэн. ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллахыг хэвтэн эмчлүүлэх тасгийн үйлчлэгч (Г.Өлзийхишиг)-д үүрэг болгосугай.

ДАРГА **А.БАТБААТАР**

